



ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ СТАТИСТИК 2022

Улаанбаатар хот
2023 он

Статистик үзүүлэлтийг боловсруулж, эмхэтгэсэн:

Э.Шинэцэцэг (Эрдэм шинжилгээ, сургалт, хөгжүүлэлтийн төвийн чанарын удирдлагын менежер, цагдаагийн ахлах дэслэгч)

Хянасан:

Ц.Мөнхбат (Бүртгэл, мэдээлэл, технологийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа)

Статистик мэдээ бэлтгэсэн:

Д.Орхонсэлэнгэ (Захиргаа, удирдлагын газрын тайлан мэдээ хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч)

Б.Бат-Уянга (Нийслэлийн шүүх шинжилгээний газрын мэргэжилтэн, цагдаагийн ахмад)

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ	3
ШИНЖИЛГЭЭ	4
Криминалистикийн шинжилгээ	9
Тусгай шинжилгээ	20
Шүүх эмнэлгийн шинжилгээ	26
Эдийн засгийн шинжилгээ	43
ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ	44
Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгт оролцсон байдал	46
Шинжээч эмч нар хэргийн газрын үзлэгт оролцсон байдал	48

ӨМНӨТГӨЛ

Шүүх шинжилгээний ерөнхий газрын бүртгэл, мэдээлэл технологийн хэлтсээс тус байгууллагын 2022 онд улсын хэмжээнд хийгдсэн шинжилгээг чиг үүргийн дагуу урьд жилүүдэд хийгдсэн шинжилгээний тоотой харьцуулж, тоон үзүүлэлтүүдээр диаграмм, хүснэгтэн мэдээлэл боловсруулж 10 дахь жилдээ та бүхэнд хүргэж байна.

Бэлтгэн хүргүүлж буй “Шүүх шинжилгээний статистик 2022” товхимолд урьд жилүүдэд хийсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг харьцуулан харуулсан нь шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, судалгаа, шинжилгээ хийх, мөн цаашилбал төсөв, төлөвлөгөө боловсруулах зэрэгт чухал ач холбогдолтой гэдгийг дурдах нь зүйтэй.

Энэхүү “Шүүх шинжилгээний статистик 2022” товхимлыг та бүхэн судалгаа, шинжилгээний үйл ажиллагаандаа үр бүтээлтэй ашиглана гэдэгт итгэж байна.

Эмхэтгэлтэй танилцсан та бүхэн цаашид шинжилгээний статистикийг боловсронгуй болгох, сайжруулах тал дээр санал, зөвлөмж, шүүмжээ Бүртгэл, мэдээлэл, технологийн хэлтсийн info@nfa.gov.mn хаягаар ирүүлэхийг хүсье.


ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР

ШИНЖИЛГЭЭ


Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд улсын хэмжээнд 69201 шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 10777 шинжилгээ буюу 18.3 хувиар өссөн. Нийт шинжилгээний 62.4 хувийг шүүх шинжилгээний төв байгууллагад, 31.4 хувийг орон нутгийн шүүх шинжилгээний хэлтсүүд, 6.1 хувийг нийслэлийн шүүх шинжилгээний газрын хэргийн газрын үзлэгийн багууд хийжээ. Ш

Шинжилгээний төрлөөр авч үзвэл 60.3 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 26.5 хувийг тусгай шинжилгээ, 12.8 хувийг криминалистикийн шинжилгээ, 0.2 хувийг эдийн засгийн шинжилгээ, 0.1 хувийг экологийн шинжилгээ эзэлж байна.

Диаграмм 1. 2022 онд хийгдсэн нийт шинжилгээг чиглэл тус бүрээр харуулав.









Шүүх шинжилгээний ерөнхий газар









Шүүх шинжилгээний ерөнхий газар






Хүснэгт 1. Шүүх шинжилгээний байгууллагад хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлтийг сүүлийн 10 жилээр харьцуулав.

КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ										
Шинжилгээний төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
 Гарын мөр	5331	6743	8420	10319	9541	9564	7506	6660	5384	5249
 Мөр судлал	1178	1296	1709	2012	1545	1557	1748	1556	1394	1300
 Бичиг баримт	1067	1295	1402	1207	1066	1013	1245	915	684	902
 Галт зэвсэг	271	216	302	249	222	606	947	877	677	736
 Тэсрэх төхөөрөмж	12	2	7	7	7	2	4	13	2	6
 Дүр зураг	104	154	140	133	98	72	53	37	15	21
 Дүрс бичлэг	54	172	257	229	265	251	244	244	243	204
 Авто техник	51	166	303	218	235	166	174	215	226	261
 Компьютер судлал	-	30	50	132	131	112	92	119	77	100
 Дуу авиа	-					28	28	23	15	17
 Материал судлал	-					33	65	5	40	48
 Бусад	-	11	51	116	92	17	15	29	5	33
НИЙТ	8068	10085	12641	14622	13202	13421	12121	10693	8762	8877

ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Шинжилгээний төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
 Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	29370	31535	31477	30168	27934	27493	27138	25919	22949	29010
 Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1200	1360	1555	1716	1409	1430	1649	1504	1178	1401
 Цогцост хийсэн шинжилгээ	3521	3742	3686	3685	4016	4499	4685	4407	4561	5353
 Эксгумац	25	39	30	24	19	26	24	17	11	10
 Эд эсийн шинжилгээ	2888	3527	3536	3621	3492	4211	5110	3345	3246	3823
 Хүний биед хийсэн бусад шинжилгээ	1099	1039	1127	1209	1220	1425	1575	1734	1686	2102
НИЙТ	38103	41242	41411	40423	38090	39084	40181	36926	33631	41699

ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИУДАД ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ

Шинжилгээний төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
 Биологи	5281	6107	6174	5734	5679	6330	6832	6125	5977	6504
 ДНХ-ийн шинжилгээ	546	869	1277	1070	1265	1432	1958	2030	1757	2240
 Бактериологи	899	877	965	893	994	1082	965	1062	1038	1379
 Хими	4747	5529	5286	5348	5894	6835	7446	6976	6931	8091
 Физик	156	169	192	179	170	207	237	249	133	150
НИЙТ	11629	13551	13894	13224	14002	15886	17438	16442	15836	18364

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ										
Шинжилгээний төрөл	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022
 Эдийн засаг	216	285	291	256	231	233	237	260	191	169



ЭКОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ		
Шинжилгээний төрөл	2021	2022
 Экологийн шинжилгээ	4	92

График1. Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээний тоон үзүүлэлт (сүүлийн 10 жилийн байдлаар)



КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ


Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд криминалистикийн 8877 шинжилгээ хийсэн бөгөөд өмнөх оноос 1.3 хувиар өссөн байна. Нийт шинжилгээний 40.4 хувийг криминалистикийн шинжилгээний газарт, 36.3 хувийг нийслэлийн шүүх шинжилгээний газрын хэргийн газрын үзлэгийн багууд, 23.3 хувийг орон нутгийн шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээч нар хийсэн байна.

Хүснэгт2. Криминалистикийн шинжилгээний 2022 оны статистик мэдээ

№	Аймаг	Нийт шинжилгээ	Үүнээс шинжилгээний төрөл:											
			Гарын мөр	Мөр судлал	Баримт бичиг	Галт зэвсэг	Тэсрэх төхөөрөмж	Дур зураг	Дүрс бичлэг	Авто техник	Компьютер судлал	Дуу авиа	Материал судлал	Бусад
1	Архангай	95	46	18	31									
2	Баян-Өлгий	57	12	28	16	1								
3	Баянхонгор	77	52	16	8	1								
4	Булган	73	53	17	2					1				
5	Говь-Алтай	24	7	8	3	6								
6	Говьсүмбэр	3	1	2										
7	Дархан-Уул	106	44	45	17									
8	Дорноговь	99	80	19										
9	Дорнод	120	95	24	1									
10	Дундговь	74	68	4	2									
11	Завхан	76	33	39	3	1								
12	Орхон	191	144	36	11									
13	Өвөрхангай	131	103	23	3	2								
14	Өмнөговь	22	15	5	1	1								
15	Сүхбаатар	66	53	9	2	2								
16	Сэлэнгэ	155	128	22	5									
17	Төв	206	197	9										
18	Увс	63	30	20	10	3								
19	Ховд	106	60	27	13	5	1							
20	Хөвсгөл	71	41	18	10	2								
21	Хэнтий	254	217	27	7	3								
22	НШШГ	3222	3199	11	12									
23	КШГ	3586	571	873	745	709	5	21	204	260	100	17	48	33
24	Бүгд	8877	5249	1300	902	736	6	21	204	261	100	17	48	33

Шүүх шинжилгээний ерөнхий газар

Диаграмм 2. Хэргийн төрлөөр харуулав.



Диаграмм 3. Шинжилгээг хийсэн үндэслэлээр авч үзвэл.






График 2. Сүүлийн 10 жилд хийгдсэн Криминалистикийн зарим шинжилгээг харьцуулан харуулав.



КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ


Криминалистикийн шинжилгээний газарт 2021 онд 69140 объекттой, 3562 шинжилгээ хийсэн бол 2022 онд 34725 объекттой, 3586 шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 0.07 хувиар өссөн байна.

График 3. Криминалистикийн шинжилгээний газарт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт




Нийт хийгдсэн шинжилгээний 78 хувь нь эрүүгийн, 11 хувь нь иргэний, 10 хувь нь захиргааны, 1 хувь нь зөрчлийн хэрэг байна.

Диаграмм 4. Криминалистикийн шинжилгээний төрөл:



Шинжилгээний 92 хувийг мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, 6 хувийг шүүгчийн захирамж, 2 хувийг эрх бүхий байгууллагын хүсэлт эзэлж байна.

Диаграмм 5. Криминалистикийн шинжилгээг хийсэн үндэслэл



Нийт шинжилгээний 93.8 хувийг цагдаагийн байгууллагаас томилсон шинжилгээ эзэлж байгаа бөгөөд бусад шинжилгээг шүүх, прокурор, бусад эрх бүхий байгууллагын тогтоол, захирамж, хүсэлтээр хийсэн байна.

График 4. Шүүхээс ирүүлсэн криминалистикийн шинжилгээний тоон үзүүлэлт




График 5. Нийслэлийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн криминалистикийн шинжилгээний тоон үзүүлэлт




График 6. Орон нутаг дахь цагдаагийн байгууллагаас ирүүлсэн криминалистикийн шинжилгээний тоон үзүүлэлт






График 7. Шинжилгээ хийлгүүлэхээр ирүүлсэн бусад байгууллагууд



НИЙСЛЭЛИЙН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙГДСЭН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн шүүх шинжилгээний газрын Хэргийн газрын үзлэгийн багууд 2022 онд 3222 шинжилгээ хийсэн бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.1 хувиар өссөн байна.

График 8. Нийслэлийн шүүх шинжилгээний газарт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт




Шинжилгээний төрлөөр нь авч үзвэл гарын мөрний шинжилгээ дийлэнх буюу 99.3 хувийг, мөр судлал 0.3 хувь, бичиг баримтын шинжилгээ 0.3 хувийг эзлэх бөгөөд нийт шинжилгээг мөрдөгч, прокурорын тогтоолоор хийжээ.

АЙМГУУДЫН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ ХИЙСЭН КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖИЛГЭЭ


Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст 2022 онд нийт 21750 шинжилгээ хийсэн бөгөөд үүний 17026 буюу 78 хувь нь шүүх эмнэлгийн, 2069 буюу 10 хувь нь криминалистикийн, 2655 12 хувь нь тусгай шинжилгээ хийгджээ.

Диаграмм 6. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийгдсэн шинжилгээг шинжилгээний төрлөөр харуулав.



Дархан-Уул аймгийн шүүх шинжилгээний хэлтэс хамгийн олон шинжилгээ буюу 1773 шинжилгээ, Төв аймгийн шинжилгээний хэлтэс 1665 шинжилгээ, Ховд аймаг 1550 шинжилгээг тус тус хийжээ.

График 9. 2022 онд хийгдсэн шинжилгээ (аймгаар)



Криминалистикийн шилжилгээний хувьд нийт 2069 шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 0.9 хувиар өссөн байна. Хамгийн олон шинжилгээ буюу 254 шинжилгээг Хэнтий аймаг, 204 шинжилгээг Төв аймаг, 191 шинжилгээг Орхон аймгийн шүүх шинжилгээний хэлтэс хийсэн байна.

Нийт шинжилгээний 71.4 хувийг гарын мөр, 20 хувийг мөр судлал, 7 хувийг баримт бичгийн, 1.3 хувийг галт зэвсгийн шинжилгээ эзэлж байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газар

Диаграмм 7. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийгдсэн криминалистикийн шинжилгээг төрлөөр нь харуулав.






График 10. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийсэн криминалистикийн шинжилгээг өмнөх онтой харьцуулан харуулав.



Шүүх шинжилгээний ерөнхий газар

Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийсэн криминалистикийн шинжилгээний нийт дүнд гарын мөрний шинжилгээ дийлэнх хувийг эзэлж байгаа бол Өвөрхангай, Сүхбаатар аймгуудад мөр судлалын шинжилгээ харьцангуй их хувийг эзэлж байна.

График 11. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийсэн криминалистикийн шинжилгээг төрлөөр нь харьцуулан харуулав



ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭ

Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд тусгай шинжилгээ нийт 18364 хийгдсэн нь өмнөх оноос 13.7 хувиар өссөн.


2022 онд тусгай шинжилгээний чиглэлээр хийгдсэн нийт шинжилгээний 44 хувийг хими, 35.4 хувийг биологи, 12 хувийг ДНХ, 7.5 хувийг бактериологи, 0.8 хувийг физикийн шинжилгээ тус тус эзэлж байна.

Дээрх шинжилгээний 85.5 хувийг тусгай шинжилгээний газарт 14.5 хувийг аймгуудын шүүх шинжилгээний хэлтсүүдэд хийгджээ.

Хүснэгт 3. Тусгай шинжилгээний 2022 оны статистик мэдээнээс.

№	Аймаг	Нийт шинжилгээ	Үүнээс шинжилгээний төрөл:					
			Хими	Физик	Биологи	ДНХ-ээр эцэг толгоох шинжилгээ	ДНХ-ийн бусад шинжилгээ	Бактерлоги
1	Архангай	293	184		109			
2	Баян-Өлгий	115	115					
5	Говь-Алтай	217	173		44			
7	Дархан-Уул	315	159		156			
9	Дорнод	298	189		109			
11	Завхан	84	84					
12	Орхон	354	281		73			
15	Сүхбаатар	77	77					
16	Сэлэнгэ	242	159		83			
18	Увс	232	139		93			
19	Ховд	236	182		54			
20	Хөвсгөл	192	192					
22	ТШГ	15709	6157	150	5783	575	1665	1379
23	Бүгд	18364	8091	150	6504	575	1665	1379

Диаграмм 8. Тусгай шинжилгээ /тоогоор/




ТУСГАЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Шүүх шинжилгээний газрын тусгай шинжилгээний газарт 2022 онд 15709 шинжилгээ хийгдсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 17 хувиар өссөн байна.


Нийт шинжилгээний 6157 буюу 39 хувь нь химийн, 5783 буюу 36.8 хувь биологийн шинжилгээ байна.

График 12. Тусгай шинжилгээний лабораторид сүүлийн 3 жилд хийгдсэн шинжилгээ




Шүүх шинжилгээний ерөнхий газар

График 13. Тусгай шинжилгээний лабораторид хийгдсэн шинжилгээг шинжилгээ хийсэн үндэслэлээр харуулав.



Диаграмм 9. 2022 онд Тусгай шинжилгээний лабораторид хийсэн хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээний тоон үзүүлэлт



Тусгай шинжилгээний лабораторид хийсэн шинжилгээнүүдийг томилсон байгууллагаар нь авч үзвэл шүүх, шүүгчийн захирамжаар 552, мөрдөгч, прокурорын тогтоолоор 5556, шинжээч эмчийн илгээх бичгээр 9570, эрх бүхий байгууллагын хүсэлтээр 31 шинжилгээ хийлгэсэн байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газар

Диаграмм 10. Тусгай шинжилгээний лабораторид шинжилгээ томилж ирүүлсэн байгууллага






График 14. Тусгай шинжилгээний газарт нийслэлийн цагдаагийн байгууллагаас ирүүлсэн шинжилгээний тоон үзүүлэлт



Шүүх шинжилгээний ерөнхий газар

График 15. Тусгай шинжилгээний лабораторид хийсэн орон нутгийн эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шинжилгээний тоон үзүүлэлт




АЙМГУУДЫН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ ХИЙСЭН ХИМИ, БИОЛОГИЙН ШИНЖИЛГЭЭ

Хими, биологийн лаборатори бүхий аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст нийт 2655 шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 11 хувиар өссөн байна. Орхон, Дархан-Уул, Дорнод аймгуудад хамгийн их шинжилгээг хийсэн байна.

Диаграмм 11. Аймеуудын шүүх шинжилгээний хэлтэст хийсэн шинжилгээг төрлийн хувьд авч үзвэл.



График 16. Аймеуудын шүүх шинжилгээний хэлтэст хийсэн хими, биологийн шинжилгээний тоон үзүүлэлт




ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд шүүх эмнэлгийн чиглэлээр 41699 шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 23 хувиар өссөн байна. Хийгдсэн шинжилгээний 74.6 хувь нь хүний биед, 13 хувь нь цогцост, 9.1 хувь нь эд эсийн, 3.4 хувь нь хэргийн материалаар хийсэн шинжилгээ тус тус эзэлж байна. Нийт шинжилгээний 59 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээний газарт, 41 хувийг аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийжээ.


Хүснэгт 4. Шүүх шинжилгээний байгууллагад хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээг төрлөөр нь харуулав.

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцост хийсэн шинжилгээ	5353
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	29010
Хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох)	2102
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1401
Эксгумаци	10
Гистологийн шинжилгээ	3823
НИЙТ	41699

Диаграм 12. Шүүх эмнэлгийн шинжилгээ төрлөөр.



Диаграм 13. Шинжилгээ хийгдсэн хийгдсэн газраар.




Хүснэгт 5. Шүүх эмнэлгийн шинжилгээний статистик мэдээ.


Аймаг	Нийт шинжилгээ	Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Хүний биед хийсэн бусад шинжилгээ	Үүнээс:		Цогцост хийсэн шинжилгээ	эксгумац	хавтаст хэргийн материалаар хийсэн шинжилгээний тоо	Эд эсийн шинжилгээ
				Бэлгийн холбогдолтой	Нас тогтоох				
Архангай	573	434	20	19	1	107	0	12	0
Баян-Өлгий	927	858	21	21	0	46	2	0	0
Баянхонгор	805	597	69	69	0	106	0	33	0
Булган	289	179	32	31	1	76	0	2	0
Говь-Алтай	396	314	24	24	0	58	0	0	0
Говьсүмбэр	273	236	6	6	0	31	0	0	0
Дархан-Уул	1352	1139	36	33	3	152	0	2	23
Дорноговь	880	744	30	30	0	106	0	0	0
Дорнод	1013	711	41	39	2	127	0	20	114
Дундговь	425	319	17	17	0	68	0	21	0
Завхан	720	578	28	26	2	91	0	0	23
Орхон	961	718	72	68	4	149	1	21	0
Өвөрхангай	880	707	42	39	3	131	0	0	0
Өмнөговь	772	538	35	31	4	171	0	22	6
Сүхбаатар	652	559	42	42	0	51	0	0	0
Сэлэнгэ	786	623	9	9	0	154	0	0	0
Төв	1459	805	22	18	4	245	0	142	245
Увс	759	555	21	21	0	86	0	8	89
Ховд	1208	976	55	55	0	74	0	30	73
Хөвсгөл	856	556	68	65	3	232	0	0	0
Хэнтий	1040	825	50	46	4	156	0	9	0
ШЭШГ	23659	15189	1337	1288	49	2810	7	1066	3250
НШШГ	1014	850	25	24	1	126	0	13	0
Бүгд	41699	29010	2102	2021	81	5353	10	1401	3823

Шүүх шинжилгээний ерөнхий газар

График 17. Шүүх эмнэлгийн цогцост хийсэн шинжилгээгээр тогтоогдсон нас баралтын зонхилох шалтгаанууд (улсын хэмжээнд)



Диаграмм 14. Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ гэмтлийн зэрэг тогтоогдсон байдлаар.



ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР


Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 2022 онд 23659 шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 31 хувиар өссөн байна.

Шинжилгээний төрөл, чиглэлээр нь авч үзвэл хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 64 хувь, хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох) 5.7 хувь, цогцост хийсэн шинжилгээ 11 хувь, эд эсийн шинжилгээ 13.7 хувь, хэргийн материалаар хийсэн шинжилгээ 4.5 хувь, шарилд хийсэн шинжилгээ 0.03 хувийг эзэлж байна.

Хүснэгт 6. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн шинжилгээ

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцост хийсэн шинжилгээ	2810
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	15189
Хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох)	1337
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	1066
Шарилд хийсэн шинжилгээ (эксгумаци)	7
Гистологийн шинжилгээ	3250
НИЙТ	23659

Диаграмм 15. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийсэн нийт шинжилгээнд төрөл, чиглэлийн эзлэх хувь



Цогцост хийсэн шинжилгээ:

Тус газар 2022 онд шинжилгээ хийлгэх тогтоолын дагуу **3154** цогцсыг бүртгэж хүлээн авснаас **2810** цогцост шинжилгээ хийж, **344** цогцост эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр шинжилгээ хийгдээгүй байна.

График 18. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 2022 онд хийгдсэн цогцост хийсэн шинжилгээгээр тогтоогдсон нас баралтын шалтгаан





График 19. Шүүх эмнэлгийн цогцост хийсэн шинжилгээгээр тогтоогдсон нас баралтын зонхилох хоёр шалтгааныг насны ангиллаар харуулав




Шүүх шинжилгээний ерөнхий газар

График 20. ШЭШГ-т цогцост хийсэн шинжилгээг шинжээч томилсон байгууллагаар харуулав.



2022 онд 2810 цогцост шинжилгээ хийснээс хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй 91 цогцсыг журмын дагуу оршуулсан байна.

График 21. Хэн болох нь тогтоогдоогүй, хариуцах эзэнгүй хүний цогцос оршуулсан байдал (сүүлийн 10 жилийн байдлаар)




Хүний биед хийсэн шинжилгээ:

Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт 2022 онд 23659 шинжилгээ хийснээс 16526 нь хүний биед хийгдсэн шинжилгээ байна. Үүнээс гэмтлийн зэрэг тогтоох 15189, бэлгийн маргаантай асуудалд хийсэн 1288, нас тогтоох 49 шинжилгээ байна.

Хүснэгт 7. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээг шинжилгээ хийсэн шалтгаан, шинжлүүлэгчийн хүйс, насны ангиллаар харуулав.

Үзлэгийн хэлбэр, шалтгаан	Зодоон	Зам тээврийн осол	Бэлгийн хүчирхийлэл	Нас тогтоох	Хутга	Буу	Бусад	ГБ зодоон	ГББХ	Нийт	
Бүгд	9595	3032	1231	49	365	4	1080	1113	57	16526	
Хүйс	Эр	6699	1647	408	17	319	4	688	174	9969	
	Эм	2896	1385	823	32	46		392	939	6557	
Насны ангилал	0-1	2	7	0	1	-	-	1	1	-	12
	1-4	20	92	33	-	-	1	31	16	-	193
	5-9	61	200	57	-	1	-	68	22	8	417
	10-14	390	270	220	18	2	-	80	35	19	1034
	15-19	756	284	280	11	14	-	81	41	9	1476
	20-24	1456	306	211	1	35	-	95	82	3	2189
	25-29	1511	270	121	2	50	1	109	177	1	2242
	30-34	1734	338	126	1	70	-	125	234	6	2634
	35-39	1328	288	67	1	56	1	113	183	2	2039
	40-44	842	233	46	-	58	1	105	141	6	1432
	45-49	569	199	34	1	39	-	81	79	1	1003
	50-54	413	154	18	2	21	-	82	36	1	727
	55-59	251	143	13	5	12	-	44	25	1	494
	60-64	158	116	3	3	5	-	34	19	-	338
	65 дээш	104	132	2	3	2	-	31	22	-	296

График 22. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийлгэсэн зонхилох хоёр шалтгааныг насны ангиллаар харуулав.



Шүүх шинжилгээний ерөнхий газар

Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 15189 шинжилгээ хийсний 5.1 хувь нь хүнд, 9.6 хувь нь хүндэвтэр, 55 хувь нь хөнгөн гэмтлийн зэрэг тогтоогдсон, нийт шинжилгээний 20.8 хувь нь гэмтлийн зэрэгт хамаарахгүй, 9.5 хувь нь гэмтэл тогтоогдоогүй гэсэн дүгнэлт гарсан байна.

График 23. Гэмтлийн зэрэг тогтоогдсон байдал




График 24. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт гэмтлийн зэрэг тогтоох шинжээч томилсон цагдаагийн байгууллага(Нийслэл)




График 25. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт гэмтлийн зэрэг тогтоох шинжээч томилсон цагдаагийн байгууллага (Аймаг)





График 26. Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт гэмтлийн зэрэг тогтоох шинжээч томилсон бусад байгууллага



Шүүх шинжилгээний ерөнхий газар


2022 онд Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт нэг цэгийн үйлчилгээгээр 27 иргэн буюу гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 7, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 20 иргэн үзүүлсэн байна.

График 27. Нэг цэгийн үйлчилгээгээр сүүлийн 8 жилд үйлчлүүлсэн иргэдийн тоо



Хэргийн материалаар нийт 1066 шинжилгээ ирснээс гэмтлийн зэрэг тогтоох 729, нас барсан шалтгааныг тогтоох 165, эмчийн үйл ажиллагаатай холбоотой 76, ялаас чөлөөлөх 27, сэтгэцийн холбогдолтой 1, эрүүл мэндийн байдал тогтоох 68 шинжилгээ байна.

Диаграмм 16. Хэргийн материалаар ирүүлсэн шинжилгээний хэлбэрүүд



Диаграмм 17. Хэргийн материалаар ирсэн шинжилгээний төрлүүд



График 28. Нийслэлийн эрх бүхий байгууллагаас шинжилгээ томилсон байдал





График 29. Орон нутгийн эрх бүхий байгууллагаас шинжилгээ томилж ирүүлсэн байдал.



НИЙСЛЭЛИЙН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ХИЙСЭН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн шүүх шинжилгээний газарт шүүх эмнэлгийн чиглэлээр 1014 шинжилгээ хийснээс хүний биед хийсэн шинжилгээ 86.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 8. Нийслэлийн шүүх шинжилгээний газарт хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээг төрлөөр нь харуулав

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Цогцост хийсэн шинжилгээ	126
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	850
Хүний биед хийсэн бусад шинжилгээ /бэлгийн холбогдолтой, нас тогтоох/	25
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	13
НИЙТ	1014

Шүүх шинжилгээний ерөнхий газар

График 30. Нийслэлийн шүүх шинжилгээний газарт хийгдсэн шүүх эмнэлгийн шинжилгээний төрөл.





График 31. Нийслэлийн шүүх шинжилгээний газарт хийгдсэн шинжилгээгээр гэмтлийн зэрэг тогтоосон байдал




АЙМГУУДЫН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ ХИЙСЭН ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ

Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст шүүх эмнэлгийн 17026 шинжилгээ хийсэн нь өмнөх оноос 16.7 хувиар өссөн, хүний биед хийсэн шинжилгээ 80.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 9. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийсэн шүүх эмнэлгийн шинжилгээ

Шинжилгээний төрөл	Шинжилгээний тоо
Шүүх эмнэлгийн цогцос шинжилгээ	2417
Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	12971
Хүний биед хийсэн бусад шинжилгээ (бэлгийн холбогдолтой, нас тогтоох)	740
Хэргийн материалаар хийсэн шинжилгээ	322
Эксгумаци	3
Гистологийн шинжилгээ	573
НИЙТ	17026


График 32. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийгдсэн шүүх эмнэлгийн шинжилгээ




Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст 12971 гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ хийсэн нь өмнөх оныхоос 17.6 хувиар өссөн байна. Дархан-Уул аймаг 1139, Ховд аймгийн шүүх шинжилгээний хэлтэст 976 шинжилгээ хийсэн нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газар

График 33. Аймгуудын шүүх шинжилгээний газарт хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ.




Диаграмм 18. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хийгдсэн гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээгээр тогтоогдсон гэмтлийн зэргийг дундажлан авч үзлвэл.



Хүснэгт 10. Гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ

Аймаг	Нийт гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ	Үзлэгээр тогтоогдсон гэмтэл				
		Хүнд	Хүндэвтэр	Хөнгөн	Гэмтлийн зэрэгт хамаарахгүй	Гэмтэл тогтоогдоогүй
Архангай	434	29	35	170	108	92
Баян-Өлгий	858	20	27	132	357	322
Баянхонгор	597	26	42	256	174	99
Булган	179	5	13	87	37	37
Говь-Алтай	314	14	23	81	134	62
Говьсүмбэр	236	4	9	81	69	73
Дархан-Уул	1139	55	85	349	352	298
Дорноговь	744	30	63	250	213	188
Дорнод	711	35	63	309	181	123
Дундговь	319	5	19	149	87	59
Завхан	578	25	23	178	198	154
Орхон	718	45	70	360	170	73
Өвөрхангай	707	14	35	257	162	239
Өмнөговь	538	36	54	244	92	112
Сүхбаатар	559	28	35	219	151	126
Сэлэнгэ	623	25	46	230	183	139
Төв	805	84	141	299	159	122
Увс	555	26	22	149	228	130
Ховд	976	27	35	239	341	334
Хөвсгөл	556	33	56	301	81	85
Хэнтий	825	32	62	319	184	228
Нийт	12971	598	958	4659	3661	3095

График 34. Цогцост хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт.



Шүүх шинжилгээний ерөнхий газар

Аймгуудын шүүх шинжилгээний хэлтэст хэргийн материалаар дахин бүрэлдэхүүнтэй шинжилгээ нийт 322 хийсний 168 нь анхны, 144 нь нэмэлт шинжилгээ байна.

График 35. Хэргийн материалаар хийсэн шинжилгээ






График 36. Эд эсийн шинжилгээ



ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖИЛГЭЭ

Шүүх шинжилгээний байгууллагад 2022 онд эдийн засгийн 169 шинжилгээ ирсэн. Үүнээс 107 шинжилгээний дүгнэлт гаргасан, шинжээч томилох эрх бүхий этгээдийн хүсэлтээр, санхүүгийн баримт ирүүлээгүй, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гараагүй зэрэг шалтгаанаар 61 шинжилгээ буцсан байна.


Диаграмм 19. Эдийн засгийн шинжилгээг хэргийн төрлөөр харуулав.



ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГ

Шүүх шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид улсын хэмжээнд 26596 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол шинжээч эмч нар 5352 хэргийн газрын үзлэгт¹ оролцсон байна.

Криминалистикийн шинжилгээний газрын шинжээчид 55, нийслэлийн шүүх шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид 18617, аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээчид 7924 удаа хэргийн газрын үзлэгт² мэргэжилтнээр оролцжээ.




Криминалистикийн шинжээчдийн оролцсон хэргийн газрын үзлэгийн 21.6 хувь нь хүний амь нас хохирсон, 28.7 хувь нь хулгайн, 17.3 хувь нь зам тээврийн осол, 1.6 хувь нь дээрмийн, 30.8 хувь нь бусад хэргүүд эзэлж байна.


¹Хүний амь нас хохирсон хэргийн газрын үзлэг бүрт шинжээч эмч нар оролцдог.

²ШШЕГ-ын Криминалистикийн шинжилгээний газрын шинжээчид нийслэл болон орон нутагт гарсан онц хүнд гэмт хэргийн газрын үзлэгт багийн зохион байгуулалттайгаар оролцдог.

Диаграмм 20. Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгт оролцсон байдлыг хэргийн өнгөөр харуулав /улсын хэмжээнд/




Диаграмм 21. Криминалистикийн шинжээчид хэргийн газрын үзлэгээр илрүүлж, бэхжүүлсэн биет баримт /улсын хэмжээнд




Хэргийн газрын үзлэгээр гарын мөр 16613, гутлын мөр 4058, тээврийн хэрэгслийн мөр 4266, биологийн гаралтай үл мөр 3464, эвдлэгч багажны мөр 1580, бусад үл мөр, эд мөрийн баримт 34836, бичил мөр 80 ширхгийг илрүүлж, бэхжүүлж, 134 хэргийн холбогдогчийг халуун мөрөөр нь олж тогтоосон байна.

**НИЙСЛЭЛИЙН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭСТ
КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИД
ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ**

График 37. Нийслэлийн шүүх шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн газрын үзлэгийн тоо



Диаграмм 22. Нийслэлийн шүүх шинжилгээний газрын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн өнгө



ОРОН НУТГИЙН ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН КРИМИНАЛИСТИКИЙН ШИНЖЭЭЧИД ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ

2021 онд аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээчид нийт 6856 хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон бол 2022 онд 7924 болж, 4 хувиар өссөн байна.

График 38. Аймгуудын криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн газрын үзлэг





График 39. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн криминалистикийн шинжээчид мэргэжилтнээр ажилласан хэргийн өнгө



ШИНЖЭЭЧ ЭМЧ НАР ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ ОРОЛЦСОН БАЙДАЛ

Шүүх шинжилгээний байгууллагын хэмжээнд шинжээч эмч нар 5352 хэргийн газрын үзлэгт оролцсоноос 3154 буюу 59 хувьд нь Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын шинжээч эмч нар, 2072 буюу 38 хувьд нь аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн шинжээч эмч нар оролцсон байна.

Шүүх шинжилгээний ерөнхий газар

Диаграмм 23. Шүүх эмнэлгийн шинжилгээний газар, Нийслэлийн шүүх шинжилгээний газар болон аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн шинжээч эмч нар хэргийн газрын үзлэгт оролцсон тоо




График 40. Аймгуудын шүүх шинжилгээний хэлтсийн шинжээч эмч нар хэргийн газрын үзлэгт оролцож цогцост хийсэн үзлэгийн тоо

